



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Багахангай дүүргийн “Илч орд”
ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс Тээврийн
хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 137,186,146 (нэг зуун гучин долоон сая нэг зуун наян зургаан мянга нэг зуун дөчин зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Багахангай дүүргийн “Илч орд” ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т зөвшөөрсүгэй.


2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслүүдийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Багахангай дүүргийн “Илч орд” ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА



115050000119



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 02 сарын 17 -ны өдрийн
... А/38 ... тушаалын хавсралт

СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

/ төгрөгөөр /

д/д	Байгууллагын нэр	Автомашин марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	Багахангай дүүргийн "Илч орд" ОНӨААТҮГ	Ниссан дизель 15-26 УБГ	1995/2007	Тусгай Япон Цагаан	CW33АНV00419	-	18,315,000	Ашиглалтын хугацаа дууссан, техникийн комиссын дүгнэлтээр тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага хангахгүй, үйлдвэрлэгдсэнээс хойш 10-аас дээш жил ашиглагдсан
2		ZL-50G /ковш/ 85-23 УБ	2007/2008	Тусгай БНХАУ Шар	07080127	-	42,680,000	
3		Газ-53 75-18 УНЭ	1988/2014	Тусгай ОХУ Цэнхэр	00988710	-	20,000,000	
4		Бага оврын трактор	2004/2004	Тусгай БНХАУ Шар	-	-	2,254,346	
5		Синотрак 17-41 УБӨ	2007/2008	Тусгай БНХАУ Улаан	LZZAELMU17W3030826	-	53,936,800	
НИЙТ							137,186,146	